



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/04-НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: А.Гэрэлмаа Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
4. Аудитын тайлан	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Дотод хяналт	Error! Bookmark not defined.
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	Error! Bookmark not defined.
4.4 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл	14
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	Error! Bookmark not defined.
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
8. Аудитын илрүүлэлт.....	15
8.1 Залруулсан алдаа	Error! Bookmark not defined.
8.2 Зөвлөмж.....	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТБОНӨБАУ	Төрийн болон орон нутгийн өмчийн бараа ажил үйлчилгээ



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № СЭА-2022/04-НА-СТА-ОНА

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Сэлэнгэ Барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 01 сарын 01	2021 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	71,398,383.35	126,535,617.86
1.1.2	Дансны авлага	8,418,408.56	11,330,080.56
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		354,892.41
1.1.6	Бараа материал	2,717,459.84	3,194,456.85
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	82,534,251.75	141,415,047.68
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	8,776,535.16	4,901,743.42
1.2.2	Биет бус хөрөнгө		
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,776,535.16	4,901,743.42
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	91,310,786.91	146,316,791.10
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1.1	Дансны өглөг		0.07
2.1.1.2	Цалингийн өглөг		1.11
2.1.1.3	Татварын өр		158,521.00
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	158,522.18
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	-	158,522.18
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	91,310,786.91	146,158,268.91
2.3.11	Эздийн өмчийн дүн	91,310,786.91	146,158,268.92
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	91,310,786.91	146,316,791.10

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	65,911,199.09	123,955,810.00
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	65,911,199.09	123,955,810.00
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	1,015,433.53	
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	59,173,033.05	68,103,670.63
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	982,364.14	446,136.36
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	6,771,235.43	55,406,003.01
19	Орлогын татварын зардал	67,381.66	558,521.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	6,703,853.77	54,847,482.0
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	6,703,853.77	54,847,482.0
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	6,703,853.77	54,847,482.0
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл		-			84,606,933.14	84,606,933.14
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-	-
3	Залруулсан үлдэгдэл						-
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)					6,703,853.77	6,703,853.77
5	Бусад дэлгэрэнгүй орлого						-
6	Өмчид гарсан өөрчлөлт						-
7	Зарласан ногдол ашиг						-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
9	2020 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-	91,310,786.91	91,310,786.91
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						-
11	Залруулсан үлдэгдэл						-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					54,847,482.00	54,847,482.00
13	Бусад дэлгэрэнгүй орлого						-
14	Өмчид гарсан өөрчлөлт						-
15	Зарласан ногдол ашиг						-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
17	2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	-	-	-	-	146,158,268.91	146,158,268.91

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	71,141,659.00	133,439,719.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	68,812,171.00	133,439,719.00
1.1.2	Бусад мөнгөн орлого	2,329,488.00	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	71,266,053.09	78,302,484.49
1.2.1	Ажиллагчдад төлсөн	31,676,239.00	36,443,969.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,688,730.67	11,504,093.62
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,043,380.00	1,808,496.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	469,521.96	514,800.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,659,155.00	9,218,128.50
1.2.6	Даатгалын төлбөрт төлсөн		74,250.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	15,105,412.46	14,930,297.37
1.2.8	Бусад мөнгөн зарлага	6,623,614.00	3,808,450.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(124,394.09)	55,137,234.51
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,015,433.53	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Хүлээн авсан хүүний орлого	1,015,433.53	
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,764,590.00	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,764,590.00	
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,749,156.47)	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,873,550.56)	55,137,234.51
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	73,271,933.91	71,398,383.35
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	71,398,383.35	126,535,617.86

2.5 ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

№	Үзүүлэлт	Төсөв /төгрөгөөр/	Гүйцэтгэл /төгрөгөөр/	Зөрүү	Хувь
1	Нийт орлого /НӨАТ-гүй/	114,503,900.00	123,955,810.00	(9,451,910.00)	108.3
2	Нийт зарлагын дүн	114,503,900.00	68,549,806.99	45,954,093.01	59.9
3	Цалин хөлс	63,000,000.00	44,049,395.11	18,950,604.89	69.9
	Үндсэн цалин	60,000,000.00	44,049,395.11	15,950,604.89	73.4
	Урамшуулал	3,000,000.00		3,000,000.00	-
4	НДШ-ийн зардал	8,100,000.00	5,842,442.62	2,257,557.38	72.1
5	Бараа үйлчилгээний бусад зардал	43,403,900.00	18,657,969.26	24,745,930.74	43.0
	Программ хангамжийн зардал	1,000,000.00		1,000,000.00	-
	Түлш шатахуун	9,800,000.00	6,822,753.26	2,977,246.74	69.6
	Албан томилолт	5,000,000.00	1,690,545.45	3,309,454.55	33.8
	Сэлбэг хэрэгсэл	2,500,000.00	1,460,909.07	1,039,090.93	58.4
	Шуудан холбоо	1,000,000.00	468,000.00	532,000.00	46.8
	Бичиг хэрэг	6,403,900.00	1,428,226.70	4,975,673.30	22.3
	Сургалт	3,000,000.00		3,000,000.00	-
	Нэг удаагийн тэтгэмж	1,000,000.00		1,000,000.00	-
	Түрээсийн зардал	1,000,000.00	1,080,000.00	(80,000.00)	108.0
	Даатгалын зардал	100,000.00		100,000.00	-
	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	35,784.00	64,216.00	35.8
	Эд хогшил, тоног төхөөрөмж	4,500,000.00		4,500,000.00	-
	Үйл ажиллагааны бусад зардал	2,000,000.00	5,225,614.42	(3,225,614.42)	261.3
	Үйл ажиллагааны бус бусад зардал	1,000,000.00	446,136.36	553,863.64	44.6
	Аймгийн ЗДТГ-т гэрээний дагуу	5,000,000.00		5,000,000.00	-
6	Нийт ажиллагсдын тоо	6	6		
	Удирдах ажилтан	1	1		
	Гүйцэтгэх ажилтан	1	1		
	ИТА	3	3		
	Гэрээт инженер	1	1		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн “Сэлэнгэ барилга захиалагч” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /цаашид “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарын аудитор А.Гэрэлмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 4 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогын 123,955.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,239.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 867.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь “Улсын болон аймаг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хийгдэж буй барилга угсралт, шинэчлэлт, засвар тохижилтын ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх” гэсэн зорилготойгоор тайлант онд үйл ажиллагаа явуулсан байна.

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бүтээн байгуулалт, барилгын ажлын төсөв, санхүүг зөв зохистой төлөвлөн зарцуулах,
- Улсын болон орон нутгийн төсвийн, хувийн хөрөнгө оруулалт, төрийн оролцоотой хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдэх барилга, зам, инженерийн шугам сүлжээний угсралт, ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах, зураг төсөл зохиох ажлын захиалагчийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар буюу 100 хувь орон нутгийн өмч эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Барилга захиалагч ОНӨААТҮГ-ыг аймгийн ИТХ-ын 2014 оны 11 дүгээр тогтоолоор байгуулсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-д “*Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр СЭА-2022/04-НА-СТА-ОНА*

гаргах, **дүрмийг батлах**”, 19 дүгээр зүйл “Аймаг, нийслэлийн Хурлын бүрэн эрх”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх “Аймаг, нийслэлийн Хурал нь харьяалах нутаг дэвсгэртээ энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 тоот тогтоол “ТБОНӨБАҮ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай”,

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	71,398.4	126,535.6	55,137.2
Дансны авлага	8,418.4	11,330.1	2,911.7
Татвар НДШ-ийн авлага	-	354.9	354.9
Бараа материал	2,717.5	3,194.5	477.0
Үндсэн хөрөнгө	8,776.5	4,901.7	(3,874.8)
Нийт хөрөнгө	91,310.8	146,316.8	55,006.0
Өр төлбөр	-	158.5	158.5
Хуримтлагдсан ашиг/+/, алдагдал/-/	91,310.8	146,158.3	54,847.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	91,310.8	146,316.8	55,006.0

Банкин дахь харилцах дансанд 126,535.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдаж, өмнөх оноос мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нийт 55,137.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд касс болон харилцахаар 135,887.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 80,750.1 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 11,330.1 мянган төгрөг болж 2,911.7 мянган төгрөгөөр өссөн нь 4 аж ахуйн нэгжээс авах 6,601.8 мянган төгрөгийн авлагаас голлон шалтгаалжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 6,610.4 мянган төгрөгийн, хугацаа хэтэрсэн 4,719.7 төгрөгийн найдваргүй авлага байна. Энэхүү хугацаа хэтэрсэн 4,719.7 мянган төгрөгийн авлага нь Хушаат сумын ЗДТГ нь 2015 онд зураг төсөв хийлгэсэн боловч төсөвт суугдаагүй гэх шалтгаанаар өгөгдөөгүй найдваргүй авлага байна.

Татвар, НДШ-ийн авлага 354.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь НӨАТ-ын авлагаас шалтгаалсан байна.

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 3,194.5 мянган төгрөг болж өмнөх оноос 477.0 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр 11,735.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 11,258.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр 158.5 мянган төгрөгөөр өссөн нь орлогын албан татварын өр төлбөрийг бүрэн шилжүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 146,158.3 мянган төгрөг болж, 54,847.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

4.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг Сэлэнгэ аймгийн Засаг дарга баталсан бөгөөд 2021 оны орлогын төлөвлөгөөг 114,503.9 мянган төгрөгөөр, зарлагыг 114,503.9 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 123,955.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 68,549.8 мянган төгрөгийн зардал гарган, 55,406.0 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 123,955.8 мянган төгрөг болж төлөвлөснөөс 9,451.9 мянган төгрөг буюу 8.3 хувиар давж биелсэн нь хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 4 хуулийн этгээдийн барилгын гүйцэтгэлд гэрээний үндсэн дээр захиалагчийн хяналтыг гүйцэтгэж 11,693.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснээс голлон шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 68,549.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 45,954.1 мянган төгрөг буюу 40.1 хувиар хэмнэгдсэн нь цалин хөлс, шатахуун, албан томилолт, сэлбэг хэрэгслийн зардлуудын хэмнэлтээс голлон шалтгаалсан байна.

Тайлант оны цэвэр ашиг төлөвлөснөөс 54,847.5 мянган төгрөгөөр давсан байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 148 мэдээллээс 75 мэдээллийг хугацаанд нь, 27 мэдээллийг хугацаа хугацаа хоцроож мэдээлсэн бол 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу шагнал урамшуулал олгоогүй, зочин төлөөлөгч хүлээн авах болон бэлэг дурсгалын зардал гаргаагүй байна.

Харин төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэн тогтоогоогүй байна.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөнөөс 2 зөвлөмжийг биелүүлж, шилэн данстай холбоотой 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

/Мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	-	2	-	66.7
Нийт дүн	3	-	2	-	66.7

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **430.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.**

8.1 Зөвлөмж

1. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1 **Илрүүлэлт:** Тайлант онд 430.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 СЭА-2022/04-НА-СТА-ОНА

“Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
						Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар															
1	“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ	СЭА-2022/04-НА-СТА-ОНА	Бараа материалын худалдан авалт нь цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй.	1	430.0									1	430.0
ДҮН				1	430.0									1	430.0
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал															
1	“Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ	СЭА-2022/04-НА-СТА-ОНА	Шилэн дансанд 27 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт мэдээлээгүй	1	-					1	-				
ДҮН				1	-					1	-				
НИЙТ ДҮН				2	430.0					1	-	-	-	1	430.0